



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Гадаадад зээлээр суралцуулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам", шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сандаг овогтой Тунгалагтамирыг 2008-2009 оны хичээлийн жилээс Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны захиалгаар Канад Улсын Конкордын их сургуулийн магистрантурт хөдөлмөрийн эдийн засгийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБАЯР